



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2022 оны 1 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар
хот

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт
Үндэсний хорооны бүрэлдэхүүн батлах тухай

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 15.6-д заасныг үндэслэн Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоотой зөвшилцсөний үндсэн дээр Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай:

Засгийн газрын
төлөөлөл:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
- Сангийн дэд сайд;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;
- Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Ажил олгогчийн
төлөөлөл:

- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгч;
- Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч;
- Монголын авто замчдын холбооны ерөнхийлөгч;
- Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал;
- Монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооны дэд ерөнхийлөгч;
- Монголын их дээд сургуулиудын конкорциумын тэргүүн.

Ажилтны
төлөөлөл:

- Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч;
- Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга;

- Монголын тээвэр холбоо газрын тосны ажилтны үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга;
- Монголын үйлдвэрлэл үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга;
- Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга;
- Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Ерөнхий сайдын 2016 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 62 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ